




Хэвлэлийн мэдээ
2022 оны 6-р сарын 6

Холбоо барих
9909-1557

АмЧам Монголын “ICT Week: Web 3.0”
чуулга уулзалт амжилттай болж өнгөрлөө



УЛААНБААТАР, Монгол Улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2022 оны 6-р сарын 2-нд “Цахим эдийн засгийн хөгжлийг тодорхойлох нь” сэдэвт танилцуулга, хэлэлцүүлгийг удирдан зохион байгуулж, маргааш нь буюу 2022 оны 6-р сарын 3-ны өдөр “Мэдээлэл, харилцаа холбоо ба дижитал эдийн засаг” ажлын хорооны санаачлагаар “Веб 3.0: Дараагийн шаг” чуулга уулзалтыг ивээн тэтгэгч байгууллагууд, гишүүд, төлөөлөгч нарын хамтаар амжилттай хөтлөн явуулав.

Энэ удаагийн 6-р сарын уулзалтын сэдвийн хүрээнд УИХ-ын гишүүн Д. Цогтбаатар, Степпе Групп ХХК / ORDA-ын үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал Б. Гэрэлмаа, Монгол Экспресс компанийн ТУЗ-ын гишүүн Д. Энхбат, Обортек компанийн гүйцэтгэх захирал Б. Тамир тэргүүтэй салбарын манлайлагч нараас гадна олон улсад үйл ажиллагаатай тэргүүлэгч компаниудын төлөөлөгчид буюу Polygon Technology компанийн энтерпрайз хариуцсан дэд-захирал ноён Арпит Шарма, DLA Piper

хуулийн фирмийн партнер хатагтай Кристи Свартц зэрэг зочин илтгэгчид энэхүү хэлэлцүүлэгт оролцлоо. Тухайн сэдвийн хүрээнд технологийн дэвшил бизнесийн салбарт хэрхэн өөрчлөлт авч ирж буй тэргүүн туршлага, түүнийг оновчтой интегралчлал хийх, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, технологийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд авч хэрэгжүүлэх алхмууд болон тэдгээрийг хөхүүлэн дэмжих эко-системийг бий болгох тухай сонирхолтой хэлэлцүүлэг өрнөлөө.

Хурлыг нээж АмЧам Монголын ТУЗ-ын тэргүүн ноён Жэймс Лиотта хэлэхдээ “Бид өнөөдөртөө амьдарч байгаа мэт боловч маргаашийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалтын төлөө яваа хүмүүс билээ. Технологийн дэвшил, хурдасгуурыг ашиглан Монгол Улс олон төрлийн ажил, бизнесийг амжилттай нэвтрүүлсээр байна. Ялангуяа сүүлийн 2-3 хугацаанд технологийн компанийн өсөлт, тоо эрс нэмэгдсэнг та бүгд мэдэж байгаа. Хиймэл оюун ухаан, автоматжуулалт, интеграци зэрэг нь бидний ажил хэрэгт нэн чухал бөгөөд маргаашийг “өнөөдөр” бидэнд өгдөг гэдэг утгаараа онцгой ач холбогдолтой юм. Хувийн хэвшил манлайлж, түүнийг нь засгийн газар бодлогоор дэмжиснээр Монголын эдийн засаг илүү солонгорч, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломжоо ахиад нэгээр нэмэх боломжтой гэж харж байна” хэмээв.

АмЧам Монголын “Мэдээлэл, харилцаа холбоо, дижитал эдийн засаг” хорооны санаачлагаар зохион байгуулсан чуулга уулзалт нь нийт 250 гаруй зочид төлөөлөгч нарыг нэг дор цуглуулж, “Веб 3.0: Дараагийн шаг” гэсэн гарчгийн дор Монгол улсын цахим эдийн засаг, гарааны бизнесийн өнөөгийн дүр төрх, мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжил, түүний эрх зүйн орчин, ирээдүйд технологийн дэвшил ашиглан бизнесийн орчнид хэрхэн нөлөөлөх зэрэг сэдвүүдээр нийт 4 панел хэлэлцүүлэг, 4 модератор 20 гаруй илтгэгч нар өөр өөрсдийн байр суурь, туршлагаасаа хуваалцлаа.

Чуулганы арга хэмжээг нээж АмЧам Монголын ТУЗ-ын дэд-тэргүүн хатагтай Н. Мөнхнасан үг хэлэхдээ “Хурдацтай өсөн тэлж байгаа нийгэм, эдийн засгийн цөмд нь технологи, тэр дундаа мэдээлэл, харилцаа холбооны салбар голлох үүрэгтэй болж байна. Түүнийг хэрхэн бодит үр дүнд хүргэж ашиглах нь хэр хурдан суралцах, мэдээллийг ажил хэрэгтээ оновчтой тусгахаас ихээхэн хамааралтай. Монгол улсын хөгжил, дижитал бүтээн байгуулалтыг дэмжих зорилготой байгуулагдсан манай танхимын Мэдээлэл, харилцаа холбоо, дижитал эдийн засгийн хороо анхныхаа томоохон арга хэмжээг ийнхүү өргөн барьж байна. Бид зөвхөн хилээр тусгаарлагдаж, үндэс угсаагаар ялгарах бус хил хязгааргүй мэдээллийн орон зайд нэгэн үндэстэн болж амьдарч байгаа бөгөөд илүү гэрэлтэй, илүү сайхан ирээдүйн төлөө өнөөдөр хуран чуулах гэж ирсэн та бүхэнд талархал илэрхийлье” хэмээлээ. Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд ноён Майкл Клечески хуран цугласан зочид, төлөөлөгч, хөрөнгө оруулагч нарт хандан үг хэлсэн нь арга хэмжээ нь хоёр улсын хамтын ажиллагаа, түншлэлийг бататгаж буй явдал гэж ойлгож байна.

Түүнчлэн чуулганы үеэр Монголын шилдэг гарааны бизнесүүд төслүүдийн танилцуулга бүхий экспо ажиллаж, олон төрлийн технологийн шийдэл, токенжуулалт, блокчэйн технологийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд, ил тод хэлбэрээр хүргэж чадсан нь арга хэмжээг бусад хурлуудаас онцлог болгосон явдал байв.

Гадаадаас ирсэн төлөөлөгчид болох Polygon Technology, Chainalysis, BCW Group, ToKo, DLA Piper зэрэг салбарын тэргүүн эгнээнд зогсдог компаниудын топ удирдлага, менежерүүд Улаанбаатар хотноо айлчилсан нь ихээхэн өндөр ач холбогдолтой үйл явдал боллоо. Төлөөлөгчид хэвлэл мэдээллийн байгууллагуудтай ярилцаж, чуулганы үеэр үйл ажиллагааныхаа талаар танилцуулга хийж, олны анхаарал татсан хэлэлцүүлэгт оролцсон.

Хаалтын арга хэмжээний үеэр Степпе Групп ХХК, BCW Consulting, DLA Piper компаниуд хоорондоо хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан нь “ICT Week”-ийн онцлох үйл явдлуудын нэг болж үлдлээ.



Хоёр өдөр өрнөсөн, хөл хөдөлгөөн ихтэй чуулган, 6-р сарын уулзалтад нийтдээ 250 гаруй зочид төлөөлөгч, гарааны бизнесүүд, хөрөнгө оруулагчид, салбарын хүмүүс нэг дор чуулж, мэдлэг туршлага, мэдээлэл, зах зээлийн хөгжүүлэлт, эрх зүйн шаардлагуудыг хэлэлцсэн, үнэ цэнтэй үйл ажиллагаа болсонд бид туйлын баяртай байна.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.